

Захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
192 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ, ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИД
СУРАЛЦАГЧДАД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЕРӨНХИЙ ЖУРАМ**
Нэг. Нийтлэг үндэслэл



- 1.1 Техник технологийн дээд сургууль, харьяа политехник коллежид (цаашид сургууль гэх) суралцагчдын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх идэвх, санаачилгыг дэмжих, амжилттай суралцагчдыг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих, нийгмийн зорилтот хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор тэтгэлэг олгох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Тэтгэлгийн зорилго, төрөл, олгох байгууллага, нөхцөл зэргээс хамааруулан бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг тухайн байгууллагаас гаргасан тэтгэлэг олгох журам, тус сургуультай байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт тусгасны дагуу олгож болно.
- 1.3 Энэхүү журам нь өдрийн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдад хамаарна.

Хоёр. Тэтгэлгийн төрөл

- 2.1 Тус сургуулийн суралцагчдад олгох тэтгэлэг нь дараах төрлүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 2.1.1 Сургуулийн нэрэмжит тэтгэлэг
 - 2.1.2 Гадаад, дотоодын байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг
 - 2.1.3 Төгсөгчид, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлэг
 - 2.1.4 Бусад тэтгэлэг (оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах, сургууль хоорондын гэрээгээр суралцуулах гэх мэт)
- 2.2 Дээрх тэтгэлгийн олгох нөхцөл, тавигдах шалгуур, шалгаруулалт, олгох зэрэг үйл ажиллагааг энэхүү ерөнхий журмыг үндэслэн тус тусын журмаар зохицуулна.

Гурав. Суралцагчдад тавих нийтлэг шаардлага

- 3.1 Тэтгэлгийн шалгаруулалтад нэр дэвшигч нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1 Идэвхтэй төлөвийн суралцагч байх
 - 3.1.2 Сурлагын амжилт гаргасан байх
 - 3.1.3 Урлаг, спортын амжилт гаргасан байх
 - 3.1.4 Нийгмийн идэвх, эрдэм шинжилгээний ажлын амжилт гаргасан байх
 - 3.1.5 Монгол улсын хууль тогтоомж, сургуулийн дотоод дүрэм, журам болон сургалтын гэрээ зөрчөөгүй байна.
- 3.2 Тэтгэлгийн төрлөөс хамаарч тухайн тэтгэлгийг санхүүжүүлэгчийн нэмэлт болзол, шаардлагыг тусган оруулж болно.

Дөрөв. Тэтгэлэг зарлах, хүсэлт материал хүлээн авах, шалгаруулалт

- 4.1 Тэтгэлгийн талаарх мэдээллийг оюутан төгсөгчдийн алба хариуцан, тэтгэлэгт нэр дэвшигчийн бүрдүүлбэл зохих материалыг хүлээн авах хугацаанаас 14-өөс доошгүй хоногийн өмнө суралцагчдад зарлан, сургуулийн цахим хуудас болон вэб сайтад байршуулан мэдээлнэ.
- 4.2 Сургуулийн нэрэмжит тэтгэлгийг жилд нэг удаа зарлана. Гадаад дотоодын байгууллага, сан, төгсөгч, хувь хүний нэрэмжит тэтгэлгийг тухайн тус тусын заасан хугацаанд зарлаж шалгаруулна.
- 4.3 Байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг олгоход тавигдах шаардлага, болзол зэргийг харгалзан оюутан суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлэх, улмаар анхан шатны шалгаруулалт явуулах ажлыг оюутан төгсөгчдийн алба хариуцан зохион байгуулна.

- 4.4 Тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргаж буй суралцагч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 4.4.1 Суралцагчийн анкет
 - 4.4.2 Сурлагын дүнгийн баталгаажсан тодорхойлолт
 - 4.4.3 Ангийн зөвлөх багшийн тодорхойлолт
 - 4.4.4 Амжилт гаргасныг нотлох бичиг баримтын хуулбар
 - 4.4.5 Бусад (тэтгэлгийн санхүүжүүлэгч байгууллагаас шаардсан болон бусад нэмэлт материал)
- 4.5 Тэтгэлэгт хүсэлт гаргагч нь мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, тэтгэлэгт хамрагдахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, сургуулийн дотоод дүрэм журмыг зөрчсөн нь батлагдвал тэтгэлэг олголтыг захирлын тушаалаар цуцална.
- 4.6 Захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг явуулж дүнг баталгаажуулан оюутан төгсөгчдийн албанд хүргүүлнэ.
- 4.7 Засгийн газраас хэрэгжүүлж буй тэтгэлэг, хөтөлбөрүүдийн мэдээллийг суралцагчдад түгээх, хамруулах үйл ажиллагааг оюутан төгсөгчдийн алба зохион байгуулна.
- 4.8 Тэтгэлэг авсан суралцагчдын мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх, суралцагчдын мэдээллийг ил тод мэдээлэх үүргийг оюутан төгсөгчдийн алба хариуцан гүйцэтгэнэ.



Тав. Тэтгэлгийн санхүүжүүлэлтийн эх үүсвэр

- 3.1 Сургуулийн нэрэмжит тэтгэлгийг суралцагчийн тооноос хамааран тэтгэлэгт нэр дэвшүүлэх ба тэтгэлгийн хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн батална.
- 3.2 Тэтгэлгийн хэмжээ, санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 5.2.1 ТТДС-ийн төсөвт тусгагдсан өөрийн хөрөнгийн эх үүсвэр
 - 5.2.2 Гадаад, дотоодын байгууллага, сан, хувь хүмүүсийн хандив, тусламж
 - 5.2.3 Бусад эх үүсвэр
- 3.3 Тэтгэлгийг олгогч байгууллага, хувь хүн суралцагчдад тэтгэлгийг шууд гардуулах эсвэл ТТДС-иар уламжлан олгож болно.
- 3.4 Тэтгэлгийн санхүүжилтээс хамаарч ТТДС-иар уламжлан тэтгэлэг олгох тохиолдолд ТТДС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 3.5 Тэтгэлгийн санхүүжилтийг ТТДС-ийн дансанд гадаад валютаар хийж болох бөгөөд суралцагчид олгохдоо тухайн үеийн Монгол банкны валютын ханшаар тооцож олгоно.
- 3.6 Сургуулийн нэрэмжит тэтгэлэг нь зөвхөн сургалтын төлбөрт, тухайн улиралдаа зарцуулагдана. Тэтгэлэгт хамрагдах үеийн суралцагчийн төлбөрийн илүү төлөлтөөс хувиараа төлсөн төлбөрийн буцаан олгох эсвэл дараагийн хичээлийн жилийн сургалтын төлбөрт тооцож болох ба тэтгэлэгтэй холбоотой илүү төлөлтийг суралцагчид олгохгүй.

Зургаа. Тэтгэлгийг үргэлжлүүлэх, түдгэлзүүлэх, цуцлах

- 6.1 Тэтгэлгийн төрлөөс хамаарч тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох тохиолдолд тавигдах шаардлагын дагуу холбогдох материалын бүрдлийг оюутан төгсөгчдийн алба хянан баталгаажуулна.
- 6.2 Суралцагч хүндэтгэх шалтгааны улмаас чөлөө авсан тохиолдолд тэтгэлгийн төрлөөс хамаарч тэтгэлгийг түдгэлзүүлж болно.
- 6.3 Тэтгэлэгт хүсэлт гаргагч нь мэдээллийн үнэн зөвийг хариуцах ба захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, тэтгэлэгт хамрагдахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, сургуулийн дотоод дүрэм журмыг зөрчсөн нь батлагдвал тэтгэлэг олголтыг цуцална.

Захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
192 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ, ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ**



Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Тус сургуулийн нэрэмжит тэтгэлэг нь техникийн боловсрол, бакалавр, магистрын хөтөлбөрөөр суралцагчдын сурч боловсрох идэвхийг өрнүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцагчдыг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих, нийгмийн зорилтот хэсэгт дэмжлэг үзүүлэхэд зориулагдах ба сургалтын төлбөр хэлбэрээр олгогдоно.
- 1.2 Энэхүү журам нь өдрийн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдад хамаарна.
- 1.3 Тэтгэлэгт хамрагдсан суралцагч хос хөтөлбөрөөр суралцах тохиолдолд зөвхөн суурь мэргэжлээр нь суралцахад нь зориулан тэтгэлэг олгоно.
- 1.4 Тэтгэлгийн жилд нэг удаа 10-р сард зарлан шалгаруулна.

Хоёр. Тэтгэлэгт нэр дэвшүүлэх, шалгаруулах

- 2.1 Дараах болзлыг хангасан суралцагч тус сургуулийн нэрэмжит тэтгэлэгт нэр дэвших боломжтой. Үүнд:
 - 2.1.1 "Шилдэг суралцагч"-ийн тэтгэлэг:
 - 2.1.1.1 2 улирал дараалан 3.5 буюу түүнээс дээш голч дүнтэй суралцсан
 - 2.1.1.2 Урлаг, спорт, мэргэжлийн чиглэлээр зохиогддог улсын болон сургуулийн уралдаан тэмцээнд тодорхой амжилт үзүүлсэн байх
 - 2.1.1.3 Оюутны эрдэм шинжилгээний ажил, олимпиад, уралдаанд амжилттай оролцож шалгарсан байх
 - 2.1.2 Шилдэг элсэгчийн тэтгэлэг:
 - 2.1.2.1 Тухайн хичээлийн жилийн элсэлтийн журмаар зохицуулна.
 - 2.1.3 Тусгай нөхцөлт тэтгэлэг:
 - 2.1.3.1 Тус сургуулийн стратегийн тэргүүлэх чиглэлд багтсан хөтөлбөрөөр суралцах чин эрмэлзэлтэй суралцагчдад сурлагын түвшин, амьдралын нөхцөл бололцоог харгалзан тусгай нөхцөлөөр сонгон шалгаруулж, тэтгэлэгт хамрагдах боломж олгоно.
- 2.2 Тэтгэлэгт нэр дэвшигчийг ерөнхий журмын 4-р зүйлд заасны дагуу материалыг хүлээн авч шалгаруулна.
- 2.3 Тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

Гурав. Тэтгэлгийн хэмжээ

- 3.1 Сургуулийн нэрэмжит тэтгэлгийг суралцагчийн тооноос хамааран тэтгэлэгт нэр дэвшүүлэх ба тэтгэлгийн хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн хүрээнд захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн батална.